

Компанийн дүрэмд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай

**ҮНДЭСЛЭЛ:** Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батална гэснийг;

Компанийн тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.5 дахь заалт Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн дүрэмд тусгасан байна гэснийг;

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ гэснийг;

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах гэснийг;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2024 оны 8 сарын 29-ний өдрийн Тооллогын комиссын 24/06 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1. Компанийн дүрмийн 1.7 дахь заалтад “Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр барилгын 17 давхар. Утас: (+976) 77003322, [info@ardcredit.com](mailto:info@ardcredit.com), [www.ardcredit.com](http://www.ardcredit.com)” гэж

1.2. Компанийн дүрмийн 6.1 дэх заалтад “Компанийн нэг бүр нь 13.8 (арван гурав төгрөг найман мөнгө) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 364,000,000 (гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг хувьцаатай байна.” гэж;

1.3. Компанийн дүрмийн 6.2 дахь заалт “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 5,023,200,000 (таван тэрбум хорин гурван сая хоёр зуун мянга) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.” гэж тус тус өөрчлөх;

2. Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар) тусгаж асуугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНЗОРИГ